



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.22 № 01/14 ДУА-2017/76/СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Өлзийт сумын Цэцэрлэгийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад мал амьтад данснаас 3 толгой хонь, 3 толгой ямаа, нийт 6 толгой малыг дотоод хэрэгцээнд ашиглахаар бүртгэлээс хассан боловч хүнсний материалд орлого аваагүй, байгууллагад 645,000.00 /Зургаан зуун дөчин таван мянга/ төгрөгийн хохирол учруулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.2.1-д /өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах/, Монгол Улсын Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 2.5-д /төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ эсвэл, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;/ заасныг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.7-д /Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан/ заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Байгууллагад учруулсан хохирол болох 645,000.00 /Зургаан зуун дөчин таван мянга/ төгрөгийг Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор төвлөрүүлэх,

2. Актын биелэлтийг 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Өлзийт сумын Цэцэрлэгийн эрхлэгч Ч.Буянжаргал, нягтлан бодогч Г.Мөнхбаясгалан нарт хариуцуулав.

ТОГТООСОН¹:

АУДИТОР




Х.ГАРАМ

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ



Ч.БУЯНЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ

Г.МӨНХБАЯСГАЛАН

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.